НАЙРАМДЛЫН ТҮҮХЭНД УЛ МӨРӨӨ ҮЛДЭЭСЭН СОЁЛЫН ӨДРҮҮД

*Б.Сумьяа**

Өнөөдөр бид Найрамдлын Нийгэмлэгүүдийн Монголын нийгэмлэг анх үүсэж байгуулагдсанаас хойших 60 жилийн хугацаанд Монгол, Зөвлөлтийн ард түмний найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны түүхэнд энэ байгууллагын гүйцэтгэсэн үүрэг, оруулсан их хувь нэмрийг бахархан тэмдэглэж байна.

Тус нийгэмлэг анх соёлоор харилцах Монголын нийгэмлэг (МОКС) нэртэйгээр байгуулагдсан нь санамсаргүй хэрэг биш юм. Энэ бол БНМАУ-аас гадаад орнууд, юуны урьд Зөвлөлт Холбоот Улстай байгуулсан найрамдал хамтын ажиллагаа нь нийгмийн амьдралын бүх хүрээ, түүний дотор оюун санааны амьдралын хүрээг улам өргөн хамрах болсонтой холбоотой бизээ.

Монгол, Зөвлөлтийн ард түмний найрамдалт харилцаанд соёлын салбар дахь хамтын ажиллагаа онцгой чухал байр суурь эзэлж, бахдам сайхан үр дүнд хүрсэн бөгөөд энэхүү хамтын ажиллагааны шинж чанар, хөгжлийн үе шат, тодорхой хэлбэрүүдийн талаар урьдах илтгэл, хэлсэн үгүүдэд нилээд өргөн тусгагдлаа. Би энд уг хамтын ажиллагааны тухай бүхэлд нь өгүүлэхгүй, зөвхөн урьд гарсан санаануудад нөхвөр болгож, соёл урлагийн салбар дахь хамтын ажиллагаанд холбогдох зарим нэг баримт, дурсамжийн чанартай зүйл хэлэхийг хүсэж байна.

Монгол, Зөвлөлтийн соёлын хамтын ажиллагааны үндэс суурь нь бүүр эрт тавигдсан юм. Ардын хувьсгалын анхны жилүүд, ялангуяа 1930-аад оноос манай ард түмний үндэсний уламжлалт соёл, урлагийн суурин дээр орчин цагийн шинэ соёл төлөвшин хөгжихөд Монгол-Зөвлөлтийн харилцаа, хамтын ажиллагаа үнэлж баршгүй чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Өнөөдөр бид Монголд орчин цагийн соёл, урлагийн мэргэжлийн байгууллагууд үүсэн хөгжиж, үндэсний уран бүтээлчдийн шинэ арми төрж төлөвшсөн тухай ярихдаа Зөвлөлт Холбоот Улсаас уригдан ирж, манай оронд ажиллан соёл урлагийн ажилтан, уран бүтээлчдийн бүхэл бүтэн үеийг хүмүүжүүлэн бэлтгэж өгсөн тэр олон гайхамшигт хүний нэрийг зайлшгүй дурдах болдог. Жишээлэхэд, манайд уригдан ирж ажиллаж байсан Зөвлөлтийн театрын нэрт зүтгэлтэн А.Ефремов, А.Борейшо, Н.Уварова нарын нэрийг дурдахгүйгээр Монголд орчин цагийн театр үүсэж, жүжигчид, найруулагчдын мэргэжлийн уран чадвар өсөж хөгжсөн тухай, эсвэл П.Берлинский, А.Кондратьев, Н.Берлин-Печникова, Б.Смирнов,

---

* Б.Сумьяа - МЗНН-ийн Төв зөвлөлийн орлогч дарга асан, доктор, профессор

Ф.И.Клешко, А.Гальперин нарын тухай дурсахгүйгээр манай оронд бүх төрлийн мэргэжлийн хөгжим богино хугацаанд том амжилтанд хүрсэн тухай ярих нь үндэслэл багатай юм. Үүний нэгэн адил монгол кино гэдэг үндэсний урлагийн нэгэн шинэ том төрөл хөл дээрээ босож өндийхөд Зөвлөлтийн нэрт кино зохиолч В.Лапин, Л.Славин, З.Хацревин, И.Хейфиц, найруулагч Ю.Тарич, Трауберг, Л.Шеффер, зураглаач А.Лебедев, М.Каплан нарын зэрэг олон хүний гүйцэтгэсэн их үүргийг тэмдэглэхгүй өнгөрөх аргагүй юм. Энд нэрлэсэн болон нэрлээгүй зөвлөлтийн олон мэргэжилтэн сургагчид, уран бүтээлчдийн чин сэтгэлийн тусламж, мэргэжлийн болон зохион байгулах, сурган хүмүүжүүлэх өндөр ур чадвар нь манай урлаг соёлын алтан үеийнхэн гэж нэрлэгддэг тэр алдар цуутнууд төрж гарахад онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

Үүний нотолгоо болгож, Монголын театрын урлагийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын Ардын жүжигчин, төрийн шагналт Э.Оюун гуайн дурсамжаас нэгэн бяцхан хэсгийг та бүхний сонирхолд толилуулья. Э.Оюун гуай 1960 онд ЗХУ-д урлаг судлалын ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж, эрдмийн зөвлөлийн гишүүдийн асуултад 2 цаг гаруй хариулсан тухай хэсэгтээ өгүүлсэн нь: "Эцэст нь нэг хүн "Та хаана театрын дээд сургууль төгссөн бэ?" гэхэд нь "Би тийм сургуульд яваагүй. Улсынхаа их сургуулийн хэл зохиолын анги төгссөн" гэсэнд "Худлаа байхаа" гэв. "Яагаад?" гэж асуувал "Театрын дээд боловсролгүй хүн театрын дотоод бүтэц, үйл ажиллагааг ийм сайн мэдэж чадахгүй шүү" гэлээ. Би тэрхүү магтаалд зовж "Та намайг театрыг овоо мэдэж байна гэж үзэж байгаа бол энэ нь ЗХУ-аас манайд 1936—1950 он хүртэл очиж, биднийг урлагийн ажилд сургаж байсан мэргэжилтнүүдийн ач гавъяа. Тэдний нэг нь энэ Г.Уварова сууж байна гэж хариулж билээ" гэжээ. Ийм агуулгатай хариултыг зөвхөн соёл урлаг төдийгүй, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, харилцаа холбоо, ардын боловсрол, эрүүлийг хамгаалах гэх мэт Монголын аж ахуй, соёлын аль ч салбарт ажиллаж байсан ахмад үеийнхнээс сонсож болно гэдэгт би эргэлздэггүй.

Монголын шинэ соёл бүрэлдэн төлөвшихөд хувь нэмэр оруулсандаа зөвлөлтийн хүмүүс өөрсдөө ч баярлаж явдаг юм. Манай үзэгчдийн олон үеийнхний танил болсон ЗСБНХУ-ын ардын жүжигчин Лев Свердлинээс 1961 онд Дорноговь аймгийн хөдөлмөрчдөд бичсэн нэгэн захидалдаа "Миний хувьд Сүхбаатарын дүр бол миний уран бүтээлийн намтар дахь хамгийн гайхамшигтай, шилдэг хэсэг нь байгаа юм. Энэ дүрээрээ би бахархаж явдаг. Ард түмэнд сайнаар үнэлэгдэнэ гэдэг бол уран бүтээлч хүнд хамгийн том баяр баясгалан байдаг байх. Хэрэв монголчууд монголын ард түмний их жолоодогч Сүхбаатарын

дүрийг бүтээсний төлөө намайг одоо хүртэл дурсаж, намайг хайрлаж, үнэлж явдаг бол би аз жаргалтай хүн юм" гэжээ.

Монгол, Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг гэдэг бол манай хоёр ард түмний зүрх сэтгэлийн угт ийм л гүн гүнзгий нэвчин шингэсэн үзэл санаа, ёс суртахуун, нинжин сэтгэлийн үнэт зүйл дээр тулгуурлан ажиллаж, тэдгээрийг цааш уламжлуулан хөгжүүлэх эрхэм үйлсийг эрхэлж байгаа байгууллага юм. Үүгээрээ тус нийгэмлэгийн үе үеийн удирдлага, үе үеийн нийт ажилтнууд, олон зуун мянган гишүүд бид бахархахгүй байхын аргагүй юм.

Хэрэв манай урлаг соёлын алтан үеийнхний тухай ярихдаа бид ЗХУ-аас манай оронд уригдан ирж ажиллаж байсан тодорхой бие хүмүүсийн нэрийг дурдахад хүрдэг бол түүний дараах үеийн болон өнөөгийн монголын алдарт цуут уран бүтээлчдийн тухай ярихдаа ЗХУ-ын Москва, Ленинград, Перм, Ташкент, Ерван, Минск, Киев зэрэг олон хотууд дахь урлаг, соёлын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулиудын тухай зайлшгүй ярих болдог. 1980-аад оны байдлаар манай орон урлаг, соёлын салбарт 33 мэргэжлээр дээд, 55 мэргэжлээр дунд боловсролтой боловсон хүчин бэлтгэдэг байсан бөгөөд түүний дийлэнх олонхийг ЗХУ-д бэлтгэдэг байсан юм. Ингэхлээр Монголын соёл урлагийн салбар, түүний олон мянган уран бүтээлчид зөвлөлтийн ард түмний үлэмжийн их ач тусыг дурсахгүй, бишрэн хүндэтгэхгүй, залгамж хойд үеийнхнийхээ үзэл санаа, эрхэмлэл дээдлэл, ой санамжид өвлүүлж үлдээхгүй байх ёс суртахууны эрхгүй гэхэд хэтрүүлэг болохгүй бизээ.

Монгол, Зөвлөлтийн ард түмний соёлын харилцаа нь эхэн үедээ гол төлөв нам, төрийн байгууллагын шугамаар хэрэгжиж байсан бол Монгол, Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг гэдэг олон нийтийн байгууллага буй болсноор энэ чиглэлийн харилцаа нийгмийн бүх давхрагын оролцоотойгоор улам өргөжин хөгжих таатай нөхцөл бүрэлдсэн юм.

Монгол, Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн 1957 оны гишүүн миний бие 1980-аад онд БНМАУ-ын Соёлын яаманд ажиллаж байхдаа тус нийгэмлэлэгийн Төв зөвлөлийн орлогч даргын сонгууль хүлээж байсны хувьд Монгол, Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа, түүний хүрээнд багтаж орсон урлаг соёлын олон том арга хэмжээний гэрч болж явсандаа ямагт баярлаж явдаг юм.

Жил бүр хоёр орны найрамдлын нийгэмлэгүүдийн шугамаар харилцан зохиогддог байсан ЗСБНХУ-ын холбооны аль нэгэн улс ба БНМАУ-ын өдрүүдээс гадна Монгол Ардын хувьсгалын 50 жил, Октябрийн хувьсгалын 55 жилийн ойд зориулан 1971, 1972 онд анх зохиогдсон "Соёлын өдрүүд" хэмээх өргөн цар хүрээтэй соёл урлагийн

арга хэмжээ таван жил тутам зохиогддог уламжлал тогтсон билээ. Энд жишээ болгож 1986, 1987 онуудад манай хоёр орны харилцан зохиосон соёлын өдрүүдийн тухай эргэн дурсахад надад таатай байна.

1986 он буюу Монгол Ардын хувьсгалын 65 жилийн ойн жил, хоёр орны соёлын яамд, найрамдлын байгууллагуудын хамтран зохион байгуулсан Монголын соёлын өдрүүдийн үйл ажиллагаа 1986 оны 7 дугаар сарын 22-нд Москвагийн их театрт нээлтээ хийсэн юм. ЗХУ-д дөрөв дэх удаагаа зохиогдож байгаа манай соёлын энэ өдрүүдэд оролцсон 150 гаруй хүний бүрэлдэхүүнтэй Монголын төлөөлөгчдийг МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, Монгол, Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн Төв Зөвлөлийн дарга Ц.Намсрай толгойлж, бүрэлдэхүүнд нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн орлогч дарга Д.Цэвэгмид болон соёлын яам, уран бүтээлийн эвлэл холбоодын удирдлагууд, урлаг соёлын нэрт зүтгэлтнүүд, уран бүтээлчид оролцсон билээ.

Манай соёлын энэ өдрүүдийн хүрээнд Москва, Ленинград, Якутск, Минск хотуудад монголын урлагийн мастеруудын тоглолт, монгол киноны долоо хоног зохиогдож, Лениний нэрэмжит Улсын номын санд монгол ном, номын зураг чимэглэлийн үзэсгэлэн, Дорно дахины улс түмнүүдийн урлагийн музейд "Монголын орчин үеийн дүрслэх урлаг" үзэсгэлэн, Хувьсгалын музейд " БНМАУ өнөөдөр" гэрэл зургийн үзэсгэлэн, мөн Москвагийн Манежийн талбай дахь үзэсгэлэнгийн их танхимд хоёр орны зураачдын харилцан зохиосон уран бүтээлийн аялалын үр дүн болсон "Найрамдлын замаар" нэртэй монгол, зөвлөлтийн найман зураачдын шилдэг бүтээлийн үзэсгэлэн тус тус нээгдэж, үзэгч олны сонирхлыг татаж байсан юм. Монголын соёлын өдрүүдийн үеэр Москва хотноо хоёр орны жүжигчид, найруулагчид, зохиолчид, киночид зэрэг ажил мэргэжил нэгт нөхдийн төрөлжсөн уулзалт, ярилцлагууд зохиогдож, бүтээл, туршлагаа харилцан солилцож, хамтын ажиллагааныхаа цаашдын төлвийг ярилцаж байлаа.

Энэ өдрүүдэд болсон арга хэмжээ бүхэн дээрээс зөвлөлтийн хүмүүсийн элэгсэг дотно, сэтгэл догдлуулсан үгс сонсогдож байсныг одоо ч дурсан санахад таатай байдаг юм. "Найрамдлын замаар" аялалд оролцсон зөвлөлтийн нэрт зураач Н.Богородская хэлэхдээ: "Монгол орон хурц сайхан өнгөөрөө бидний сэтгэлийг татсан юм. Монголын ер бусын үзэсгэлэнт байгаль нь энэ нутагт аж төрж байгаа хүмүүс яагаад уян зөөлөн, сайхан сэтгэлтэй, сэтгэлийн тэнхээтэй байдгийг ойлгоход бидэнд тусалсан юм" гэж тэмдэглэсэн бол ЗСБНХУ-ын Соёлын яамны орлогч сайд, Монголын соёлын өдрүүдийг зохион байгуулах хорооны дарга Г.А.Иванов "Үнэн" сонины сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа "Монгол ардын сайхан дуу, орчин үеийн хөгжим, цоглог сайхан

бүжгээс бүрдсэн баярын концерт их театрт цугларсан үзэгчид төдийгүй, телевиз үзэгч олны сэтгэлийг булаалаа. Монгол ардын язгуур урлаг бид бүхний сэтгэлийг хичнээн их хөдөлгөснийг үгээр илэрхийлэхэд бэрх юм. Энэ бол нандигнан хайрлаж байгууштай урлагийн эх ундраа билээ. Монгол орон ардын урлагаа ингэж нандигнаж байдагт бид үнэхээр баярлаж байна. Ахмад дунд үеийнхнээр барахгүй, залуучууд энэ урлагийг эзэмшсэн нь бүр ч гайхамшигтай байна" гэжээ.

ЗХУ-д зохиогддог байсан Монголын соёлын өдрүүд гэдэг нь ямар өндөр түвшинд, хоёр орны найрамдлын үнэ цэнийг нотлон харуулсан ямар өргөн цар хүрээтэй, ямар их ажил хэрэгч арга хэмжээ болдог байсныг дээрх баримтуудаас ямар нэг хэмжээгээр олж мэдэж болно гэж бодож байна.

Октябрийн хувьсгалын 70 жилийн ойн жил буюу 1987 оны дундуур манай оронд ЗХУ-ын дөрөвдэх удаагийн соёлын өдрүүд зохиогдсон юм. Соёлын энэ өдрүүдэд оролцогсдыг ЗСБНХУ-ын Соёлын яамны сайд В.Г.Захаров, орлогч сайд П.И.Шабанов нар толгойлж ирсэн бөгөөд уул арга хэмжээнд ЗСБНХУ-ын ардын болон гавъяат жүжигчид, Бүх холбоотын болон олон улсын шагналт олон арван уран бүтээлчид, урлаг, соёлын нэрт зүтгэлтнүүд оролцсон билээ.

ЗСБНХУ-ын соёлын өдрүүд ЗХУ-ын урлагийн нэрт мастерууд, гоцлол жүжигчдийн концертоор эхэлж, Москвагийн уран сайхны академик театрын хамт олон "Ингэж ялна", "Мөнгөн хурим" зэрэг драмын жүжгээ монгол үзэгчдийн өмнө синхрон орчуулгатайгаар тоглож, Эрдэнэт хотод Бүх холбоотын болон олон улсын уралдааны удаа дараагийн шагналт эстрадын нэрт дуучин Анне Вески, гоцлол дуучин Иво Линна нарын оролцсон дуу бүжгийн "Немо" чуулгынхан ая дуугаа өргөж, хот хөдөөд зөвлөлтийн кино наадмууд зохиогдсон нь найрамдалт ЗХУ-ын соёл урлагийн гайхамшигт амжилттай Монголын олон нийтийг танилцуулахад том үүрэг гүйцэтгэсэн билээ.

Соёлын өдрүүдийн хүрээнд зохиогдсон хамгийн том арга хэмжээ нь Улаанбаатарын төв Стадионд болсон хоёр орны соёл урлагийн зүтгэлтнүүдийн "энх тайвны уулзалт-тоглолт" байв. Нийслэл хотын олон мянган хүнийг хамарч, найрамдалт хоёр орны урлаг, соёлын зүтгэлтнүүд, сансрын нисгэгчид, тамирчид, пионер сурагчид оролцсон энэ сүр жавхлант цэнгүүний тухай тэр үеийн "Үнэн" сонинд "Монгол, Зөвлөлтийн уран бүтээлчдийн энх тайвны уулзалт—тоглолт нь найрамдал нөхөрлөл, аз жаргал, энх амгалан амьдралыг бэлгэдсэн цог жавхлант ая дуу, уран бүжиг, яруу найргийн бадрангуй үгсээр үзэгчдийн сэтгэлийг баясгасан урлаг соёлын утга төгөлдөр баяр болов" гэж бичиж байв.

ЗСБНХУ-ын соёлын өдрүүдийн хүрээнд Монголын дүрслэх урлагийн музейд зөвлөлтийн зураачдын бүтээлийн үзэгсгэлэн нээгдэж, зөвлөлтийн олон үндэстнүүдийн урлагийн их мастеруудын бүтээсэн уран зураг, зураасан зургийн 100 гаруй бүтээлийг дэлгэн харуулсан бол Улсын үзэсгэлэн чимэглэлийн төв танхимд "Октябрийн ховор нандин зүйлс" үзэсгэлэн нээгджээ. Энэ өвөрмөц үзэсгэлэнд ЗХУ-ын түүхийн музей болон Москва, Ленгинград хотын таван том музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Октябрийн хувьсгалын холбогдолтой түүхэн баримт, гэрэл зураг, фото тусгалын өвөрмөц аргаар хуулбарлан харуулсан голограммын дүрслэлүүдийг дэлгэн үзүүлжээ. Мөн энэ үеэр зөвлөлтийн утга зохиолын өдрүүд зохиогдож манай үзэгч олонд хоёр орны зохиолч, яруу найрагчид зохиол бүтээлээсээ танилцуулж, зөвлөлтийн номын үзэсгэлэн худалдаа ажиллаж байв. Улаанбаатарын барилга-архитектурын үзэсгэлэнгийн танхимд "Зөвлөлтийн орчин үеийн архитектура" үзэсгэлэн ажиллаж монгол үзэгчид, мэргэжил нэгт нөхдийн сонирхлыг татаж байсан юм. Зөвлөлтийн соёлын өдрүүдэд оролцогчдын хэсэг Өмнөговь аймгаар аялж, малчин айлд зочлон, жирийн ард иргэдтэй элэгсэг дотно ярилцан хөгжилдөж, бас нутгийнхны зохиосон бэсрэг наадамд оролцсон билээ.

Энд дурдсан цөөн баримт нь нэг талаар Монгол, Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгээс Монголын ард түмнийг ЗХУ-ын ололт, туршлагатай өргөн танилцуулах эрхэм зорилгоо биелүүлэхэд нь манай хоёр орны соёлын яамдын шугамаар зохиогддог байсан соёлын өдрүүд чухал үүрэг гүйцэтгэж, нөгөө талаар хоёр ард түмний соёл харилцан баяжих, уран бүтээлчид бие биеэс харилцан суралцахад МЗНН бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж ирсний нэгэн зүйл нотолгоо мөн гэдгийг тэмдэглэн энэ бяцхан дурсамж сонсголоо төгсгөе.